



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2023 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 16

Мандалговь

**Автомашинд үнэлгээ тогтоож,
худалдах зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арванзургаадугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Адаацаг сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 8,650,000 /найман сая зургаан зуун тавин мянга/ төгрөгийн балансын үнэтэй, 944,166,76 /есөн зуун дөчин дөрвөн мянга нэг зуун жаран зургаан төгрөг далан зургаан мөнгө/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй 2 ширхэг автомашины худалдах доод үнийг нэгдүгээр хавсралтын дагуу, Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 3,080,000 /гурван сая наян мянга/ төгрөгийн балансын үнэтэй, үлдэгдэл өртөггүй автомашины худалдах доод үнийг хоёрдугаар хавсралтад заасны дагуу тогтоон нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Орон нутгийн өмчийн газрын дарга (Б.Адъяасүрэн), Адаацаг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Уранцэцэг), Эрүүл мэндийн төвийн эрхлэгч (С.Отгонбаяр) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг аймгийн хөрөнгө худалдсаны орлогын 100080000962 тоот дансанд бүрэн төвлөрүүлэх;

2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэхэд хяналт тавих;

2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2024 оны нэгдүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ОД-ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн
16 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

Адаацаг сумын Засаг даргын Тамгын газрын худалдах тээврийн хэрэгслийн мэдээлэл

№	Хуулийн этгээдийн нэр	Тээврийн хэрэгслийн нэр	Улсын бүртгэлийн		Үйлдв эрлэсэ н он	Ашиг лалт ад орсо н он	Санхүүгийн тайланд тусгагдсан дүн	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Худалдах доод үнэ
			Сери	Дугаар						
1	Адаацаг сум ЗДТГ	Фермер	ДУА	7292	2011	2011	3,500,000	3,500,000	0.00	2,500,000
2	Адаацаг сум ЗДТГ	Универсал трактор	УБ	3682	1986	2011	5,150,000	4,205,833,24	944,166,76	1,200,000
Нийт							8,650,000 /найман сая зургаан зуун тавин мянга/ төгрөг	7,705,833,24 /долоон сая долоон зуун таван мянга найман зуун гучин гурван төгрөг хорин дөрвөн мөнгө/ төгрөг	944,166,76 /есөн зуун дөчин дөрвөн мянга нэг зуун жаран зургаан төгрөг далан зургаан мөнгө/ төгрөг	3,700,000 /гурван сая долоон зуун мянга/ төгрөг

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн
№ 6 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

Адаацаг сумын Эрүүл мэндийн төвийн худалдах тээврийн хэрэгслийн мэдээлэл

№	Хуулийн этгээдийн нэр	Тээврийн хэрэгслийн нэр	Улсын бүртгэлийн		Үйлдв эрлэсэ н он	Ашиг лалт ад орсо н он	Санхүүгийн тайланд тусгагдсан дүн	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Худалдах доод үнэ
			Сери	Дугаар						
1	Адаацаг сум ЭМТөв	УАЗ-469	ДУА	7095	1905	2012	3,080,000	3,080,000	-	3,000,000
Нийт							3,080,000 /гурван сая наян мянга/ төгрөг	3,080,000 /гурван сая наян мянга/ төгрөг		3,000,000 /гурван сая/ төгрөг